МЭДЭЭ · 2026 оны 10-р сарын 7

2026 ОНЫ III УЛИРЛЫН БАЙДЛААР 7,415,455 ЗӨРЧИЛ БҮРТГЭГДЖЭЭ



Зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд 2026 оны III улирлын байдлаар нийт 7,415,455 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1.4 дахин өсжээ.

Нийт зөрчлийн 89.8 хувь нь Нийслэлд, 10.2 хувь нь орон нутагт бүртгэгдсэнээс 99.6 хувийг Цагдаагийн байгууллага, 0.4 хувийг Гадаадын иргэн, харьяатын газар, Гаалийн байгууллага, Нийгмийн даатгал, Татвар болон бусад эрх бүхий байгууллагууд шалган шийдвэрлэжээ.

Бүртгэгдсэн нийт зөрчилд шийтгэл оногдуулсан байдлыг авч үзвэл 7,301,026 буюу 98.5 хувийг газар дээр нь хялбаршуулсан журмаар, 69,174 буюу 0.9 хувийг бүртгэлд авч хялбаршуулсан журмаар, 5,992 буюу 0.1 хувьд нь эрх бүхий албан тушаалтан зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж шийтгэл оногдуулсан бол 39,263 буюу 0.5 хувьд нь шүүхээс шийтгэл оногдуулж шийдвэрлэсэн байна.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж 7,100,262 хүн, 302,226 хуулийн этгээдэд нийт 202 тэрбум 354 сая төгрөгийн торгох шийтгэл оногдуулснаас 110

тэрбум 637 сая төгрөг буюу 54.7 хувь нь төлөгджээ.

“ТАНХАЙРАХ” ЗӨРЧИЛ 10,440 БУЮУ 33.8 ХУВИАР ӨСЖЭЭ

Зонхилон үйлдэгдсэн зөрчлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих” зөрчил 7,193,198 буюу 1.3 дахин, “Жолоочийн даатгалын тухай хууль зөрчих” зөрчил 26,797 буюу 22.9 дахин, “Танхайрах” зөрчил 10,440 буюу 33.8 хувиар тус тус өссөн байна.

Харин “Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах” зөрчил 95,829 буюу 23.2 хувиар, “Автотээврийн тухай хууль зөрчих” зөрчил 25,549 буюу 3.1 хувиар, “Хүний биед халдах” зөрчил 8488 буюу 40.8 хувиар, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих” зөрчил 7164 буюу 25.2 хувиар, “Автозам, замын байгууламж, тэмдэг, тэмдэглэлийг гэмтээх, өөрчлөх, бохирдуулах” зөрчил 2546 буюу 72.5 хувиар тус тус буурсан байна.



ПРОКУРОР 3,838 ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗӨРЧИГДСӨН ЭРХИЙГ СЭРГЭЭСЭН

Прокурорын байгууллагаас эрх бүхий албан тушаалтны гомдол, мэдээллийг үндэслэлгүйгээр хүлээн авахаас татгалзсан 1,647 шийдвэрийг, хэрэгсэхгүй болгосон 563 шийдвэрийг тус тус хүчингүй болгож, мөн үндэслэлгүй шийтгэл оногдуулсан 2,948 шийдвэрийг хүчингүй болгуулж, өөрчлөлт оруулахаар дүгнэлт бичиж, 1902 дүгнэлтийг шүүхээр хянан хэлэлцүүлсний 1,779 буюу 93.5 хувь нь биелжээ.

Прокуророос хууль тогтоомжийн хэрэгжилтийг 270 удаа шалгаж, 96 удаа судлан нийт 8,743 зөрчлийг илрүүлж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагуудад 154 шаардлага хүргүүлэн, илэрсэн зөрчлийг арилгуулж, 95 албан тушаалтанд хариуцлага тооцуулжээ.

Прокурор зөрчил шалган шийдвэрлэх эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд 48,322 удаа, захиргааны хэргийн шүүх хуралдаанд 355 удаа тус тус оролцсон. Зөрчлийн улмаас хүн, хуулийн этгээд, төр нийтийн ашиг сонирхолд нийт 82 тэрбум 494 сая төгрөгийн хохирол учирснаас 43 тэрбум 796 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлөгдсөн байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/413